



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2014 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 01

Төрийн ордон, Улаанбаатар хот

Зэвсэгт хүчний Жанжин штабын дүрэм батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. “Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын дүрэм”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ зарлиг батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 171 дүгээр зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ

ХУУЛБАР ҮНЭН:
Тамгын газрын дэд дарга

Б.Нэргүй



Монгол Улсын Ерөнхийлөгчийн
2017 оны 01 дугаар сарын 04 ны өдрийн
04 дугаар зарлигийн хавсралт

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДҮРЭМ

Нэгдүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штаб /цаашид Жанжин штаб гэх/-ын үйл ажиллагааг хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, төрийн цэргийн байгууллага хоорондын харилцан ажиллагааны уялдааг хангаж зохицуулах, төрлийн болон төрөл мэргэжлийн командлал, албад, нэгтгэл, анги, байгууллагуудыг цэргийн мэргэжлийн дээд, нэгдсэн удирдлагаар хангахад энэ дүрмийг дагаж мөрдөнө.

1.2. Жанжин штабын үйл ажиллагааны үндсэн зорилго нь Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилт, цэргийн албаны эрх зүйн хэм хэмжээг тогтоох, Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч, батлан хамгаалах асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнийг цэргийн мэргэжлийн зөвлөмжөөр хангах, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагуудад цэргийн бодлого, төлөвлөлтийн дэмжлэг үзүүлэхэд оршино.

1.3. Жанжин штабыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар томилогдсон дарга тэргүүлэх ба Жанжин штабын дарга /цаашид дарга гэх/ нь Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчид цэргийн бодлогын асуудлаар зөвлөх үүрэгтэйгээр, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний удирдлага дор ажиллана.

1.4. Даргын дэргэд түүнд зөвлөх эрхтэй зөвлөл ажиллаж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг дарга тогтооно.

1.5. Жанжин штаб нь төрийн цэргийн байгууллагын цэргийн мэргэжлийн дээд удирдлагыг хэрэгжүүлнэ. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон бүтэц, орон тоог мөрдөнө.

Хоёрдугаар зүйл. Жанжин штабын үндсэн чиг үүрэг

2.1. Жанжин штаб нь Зэвсэгт хүчний тухай, Агентлагийн эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуульд заасан чиг үүргийн хүрээнд дараах үүргийг хүлээнэ:

2.1.1. Төрийн цэргийн байгууллагын цэргийн мэргэжлийн дээд удирдлагыг хэрэгжүүлэх хүрээнд:

2.1.1.1. Төрийн цэргийн байгууллагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулах;

2.1.1.2. Төрийн цэргийн байгууллагын хамтын ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд уялдуулан зохицуулах, удирдамж, чиглэл өгөх;

2.1.1.3. Улс орноо батлан хамгаалах хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн төрийн цэргийн байгууллагуудын байгуулалтыг хөгжүүлэх үндсэн асуудлуудын талаар санал боловсруулж, холбогдох дээд байгууллагад өргөн мэдүүлэх;

2.1.1.4. Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн цэргийн байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө, журам боловсруулах, хэрэгжилтийг хангахад мэргэжлийн удирдлага, дэмжлэг үзүүлэх;

2.1.1.5. Тайван болон дайны байдлын үед төрийн цэргийн байгууллагуудын хүч хэрэгслийг хэрэглэх бодлого, төлөвлөлтөнд нийцүүлэн хамтарсан сургалт, дадлага зохион байгуулж явуулах.

2.1.2. Зэвсэгт хүчнийг цэргийн мэргэжлийн нэгдмэл удирдлагаар хангах хүрээнд:

2.1.2.1. Зэвсэгт хүчний хэмжээнд Монгол Улсын хууль тогтоомж, бүх нийтээр дагаж мөрдөх журам, захиргааны хэм хэмжээний акт, Жанжин штабын даргын тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих;

2.1.2.2. Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх бодлогын үндсийг тодорхойлох, удирдлага, төлөвлөлтийн арга хэмжээг зохион байгуулах, хяналт тавих;

2.1.2.3. Төрлийн цэргийн командлалуудыг захиргааны удирдамжаар хангах, тэдгээрийн харилцан ажиллагааны үндсийг тогтоох, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;

2.1.2.4. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, бие бүрэлдэхүүний зохистой харьцааг тогтоох;

2.1.2.5. Зэвсэгт хүчний бэлэн байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг төлөвлөх, мэргэжил арга зүйн удирдамжаар хангах, зохицуулах, хяналт тавих;

2.1.2.6. Төрөл, тусгай мэргэжлийн цэргийн дүрэм, журам, зааврыг батлах, мөрдүүлэх;

2.1.2.7. Цэргийн албыг зохион байгуулах, удирдамж заавраар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

2.1.2.8. Зэвсэгт хүчний удирдлагын холбоо, мэдээллийн бодлогыг тодорхойлох, автоматжуулсан сүлжээний шуурхай, тогтвортой байдлыг хангах;

2.1.2.9. Аймаг, нийслэлийн цэргийн штабуудыг цэргийн мэргэжлийн удирдлагаар хангах;

2.1.2.10. Бүх цэргийн Их хар сүлдний хадгалалт, хамгаалалт, үйлчилгээ, залж цэнгүүлэх, тахилга үйлдэх ёслолыг зохион байгуулах;

2.1.2.11. Зэвсэгт хүчинд эрдэм шинжилгээ, судалгаа, туршилтын ажил явуулах, оюуны бүтээл, ном, гарын авлага боловсруулах чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.1.2.12. Зэвсэгт хүчний хэмжээнд цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах чиглэлийг тогтоож, хэрэгжилтэд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах;

2.1.2.13. Цэргийн алба хаагч, цэргийн баг, нэгжийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах санал, тооцоо боловсруулах, ажиллагааны өмнөх бэлтгэл болон ажиллагааны удирдлага, төлөвлөлт, материал техникийн хангалтыг зохион байгуулах, ажиллагааны туршлага, сургамжид үнэлгээ, дүгнэлт хийх;

2.1.2.14. Цэргийн хүрээ, хотхоны хязгаарыг тогтоох, албан тушаалтнуудыг томилох;

2.1.2.15. Зэвсэгт хүчний цэргийн нэгтгэл, анги, байгууллагад захидал, харилцааны дугаар олгох;

2.1.2.16. Зэвсэгт хүчний хэмжээнд цэргийн нууц хамгаалах журам, цэргийн далдуур удирдлагын горим тогтоож, хэрэгжилтэд хяналт тавих;

2.1.2.17.Төрлийн цэргийн командлал, цэргийн нэгтгэл, ангийн байлдааны туг, тамга, тэмдгийг үйлдүүлэх;

2.1.2.18.Иргэн, цэргийн харилцааг бэхжүүлэх, Зэвсэгт хүчнийг иргэдэд нээлттэй байлгах бодлого тодорхойлж, хэрэгжүүлэх;

2.1.2.19.Зэвсэгт хүчний төсвийн төслийг боловсруулж, батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад оруулах, батлагдсан төсвийг хуваарилах, захиран зарцуулах.

2.1.3.Зэвсэгт хүчний стратегийн төлөвлөлт, нэгдсэн ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд:

2.1.3.1.Төрийн цэргийн номлолын хэрэгжилтийг зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд тодотгол хийх;

2.1.3.2.Зэвсэгт хүчнийг хэрэглэх болон стратегийн дэлгэн байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулах;

2.1.3.3.Улсын хил халхлах ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийн бэлтгэлийг хангуулах;

2.1.3.4.Зэвсэгт хүчнийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах;

2.1.3.5.Зэвсэгт хүчний нэгдсэн ажиллагааны удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалт, харилцан ажиллагааг зохицуулах;

2.1.3.6.Батлан хамгаалах нутаг дэвсгэрийн төхөөрөмжлөл, цэргийн дэд бүтцийн зориулалт бүхий байгууламжуудын аюулгүй байдлыг хангах ажлыг төлөвлөх;

2.1.3.7.Онцгой нөхцөл үүссэн үед төрийн цэргийн ба цэрэгжсэн байгууллагуудтай Зэвсэгт хүчин харилцан ажиллах журам, төлөвлөгөөг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах;

2.1.3.8.Орон нутгийн хамгаалалтын бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;

2.1.3.9.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд Зэвсэгт хүчнийг ашиглах төлөвлөгөөг боловсруулж, бэлтгэлийг хангуулах;

2.1.3.10.Аймаг, нийслэлийн цэргийн дайчилгааны төлөвлөгөө, батлан хамгаалах газрыг дэлгэх болон орон нутгийн цэргийг байгуулах төлөвлөгөөг хянан батлах, тэдгээрийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангахад дэмжлэг үзүүлэх;

2.1.3.11.Зэвсэгт хүчний улсын онц чухал объектыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах;

2.1.3.12.НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа болон олон улсын цэргийн эвслийн ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй бие бүрэлдэхүүн, техник, хэрэгслийг татан гаргах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах;

2.1.3.13.Цэргийн тээвэрлэлтийн үндсэн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах.

2.1.4.Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэх, цэргийн дайчилгааны бэлтгэлийг хангах хүрээнд:

2.1.4.1.Зэвсэгт хүчин, төрлийн цэргийн байлдааны ажиллагааны бүс, чиглэл, үүргийг тогтоох;

2.1.4.2.Монгол Улсын агаарын орон зайд нислэг үйлдэх журмыг тогтоож, түүний биелэлтийг хянах, нисэх хэрэгслийн нислэгийн байдалд цэргийн мэргэжлийн хяналт тавих;

2.1.4.3.Агаарын орон зайд зөрчил гарсан үед зөрчлийг арилгах, таслан зогсоох арга хэмжээг авах;

2.1.4.4.Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх асуудлаар хөтөлбөр, төсөл боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулах;

2.1.4.5.Улсын нөөцөд байх Зэвсэгт хүчний хэрэгцээт материал хэрэгслийн төрөл, тоо, хэмжээ, байршлыг тогтоох тухай санал боловсруулж, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

2.1.4.6.Цэргийн дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний нэгдсэн тооцоог хөтлөх;

2.1.4.7.Дайчилгааны бэлтгэл нөөцийн бие бүрэлдэхүүний сургалт, давтан сургалтад нутгийн захиргааны байгууллагуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.1.4.8.Зэвсэгт хүчний цэргийн нэгтгэл, ангиудын тусгай хэрэгцээний газрын асуудлаар санал боловсруулах;

2.1.4.9.Орон нутгийн цэргийн бүтэц, зохион байгуулалт, түүний бодлогыг тодорхойлох;

2.1.4.10.Аймаг, нийслэлийн нэгдсэн, бүсчилсэн болон цэргийн дайчилгааны даалгаврыг тогтоох.

2.1.5.Цэргийн сургалт бэлтгэлийн бодлогыг тодорхойлох, цэргийн албыг бэхжүүлэх хүрээнд:

2.1.5.1.Цэргийн сургалт бэлтгэлийн болон цэргийн албаны стандартыг тогтоож мөрдүүлэх;

2.1.5.2.Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн албан тушаалын шалгуур үзүүлэлт, цэргийн мэргэжлийн зэргийн үндсэн шалгуур үзүүлэлтийг тогтоох;

2.1.5.3.Төрлийн цэргийн командлал, цэргийн нэгтгэл, ангийн штабуудын бэлтгэлийн бодлогыг тодорхойлон төлөвлөж, мэргэжлийн удирдлагаар хангах;

2.1.5.4.Зэвсэгт хүчний хүний нөөцийн бодлогыг тодорхойлж бие бүрэлдэхүүнийг бэлтгэх, давтан бэлтгэх, арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах;

2.1.5.5.Цэргийн алба хаагчийн бие бялдар, сэтгэл зүй, ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэх;

2.1.5.6.Зэвсэгт хүчинд цэрэгжлийн спорт, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.1.5.7.Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллыг сайжруулах, тэдний хууль ёсны эрх ашгийг хамгаалах ажлыг зохицуулах;

2.1.5.8.Зэвсэгт хүчний цэргийн нэгтгэл, анги, байгууллагыг байгалийн гамшиг, гэнэтийн аюул осолтой тэмцэх чиглэлээр сурган бэлтгэж, шаардлагатай үед оролцуулах, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

2.1.5.9.Зэвсэгт хүчний офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчдын цэргийн мэргэжлийн зэргийн шалгалтыг зохион байгуулах;

2.1.5.10.Зэвсэгт хүчний хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сахилга дэг журам бэхжүүлэх ажлыг төлөвлөн, зохион байгуулж, хяналт тавих;

2.1.5.11.Цэргийн албаны нэр хүндийг дээшлүүлэх, цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.

2.1.6.Зэвсэгт хүчний ар тал, зэвсэглэл, цэргийн техникийн хангалт, цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллыг бэхжүүлэх хүрээнд:

2.1.6.1.Зэвсэгт хүчний материал хэрэгслийн цэргийн болон дайчилгааны нөөцийн хэмжээг тогтоох, бүрдүүлэх, хадгалах, сольж шинэчлэх ажлыг зохион байгуулах.

2.1.6.2.Зэвсэгт хүчний цэргийн материал хэрэгслийн бүх төрлийн хангалт, үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулах,

2.1.6.3.Зэвсэгт хүчний үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах, устгах, худалдах, шилжүүлэх, шинээр авах санал боловсруулж батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдүүлэх;

2.1.6.4.Зэвсэгт хүчнийг шинэ зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслээр хангах санал боловсруулж батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

2.1.6.5.Зэвсэглэл, цэргийн техникийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, сэргээн сайжруулалт, засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн хангалтын бодлогыг хэрэгжүүлэх;

2.1.6.6.Бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн хангалт, үйлчилгээний бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг хангах.

Гуравдугаар зүйл.Жанжин штабын даргын эрх

3.1.Жанжин штабын дарга нь Агентлагийн эрх зүйн байдлын тухай, Зэвсэгт хүчний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна дараах эрхийг эдэлнэ.

3.1.1.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрлөөр гадаад орнуудын цэргийн дээд штабуудтай холбоо тогтоох, хамтран ажиллах;

3.1.2.Цэрэг-стратегийн ач холбогдол бүхий иргэний байгууламжийн байршлыг тогтооход мэргэжлийн дүгнэлт гаргах;

3.1.3.Цэргийн дайчилгааны төлөвлөгөөт сургууль, цугларалтын үед дайчилгааны нөөцийн бүрэлдэхүүн, холбоо, тээврийн болон шаардлагатай бусад материал, хэрэгслэлийг дайчлан татах;

3.1.4.Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, байгууллагууд, төрийн цэргийн байгууллагууд, аймаг, нийслэлийн цэргийн штабаас өөрийн эрхлэх асуудлын хүрээнд шаардагдах мэдээний жагсаалтыг тогтоох, шаардлагатай мэдээ, тайланг гаргуулан авах;

3.1.5.Цэргийн дайчилгааны даалгавар бүхий төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжид шалган туслах;

3.1.6.Цэргийн алба хаагчдыг хууль тогтоомжид заасны дагуу албан тушаалд томилох, чөлөөлөх, албан тушаал, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, төрийн албанаас чөлөөлөх, түр чөлөөлөх, халах;

3.1.7.Төрийн цэргийн байгууллагын дарга, төрлийн цэргийн командлагч, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн захирагч /дарга/, цэргийн штабын дарга нарт хуулиар тогтоосон чиг үүргийн хүрээнд үүрэг чиглэл өгч, биелэлтийг нь хангуулах;

3.1.8.Хууль тогтоомжоор эрх олгогдсон асуудлаар эрх зүйн хэм хэмжээг тогтоох, мөрдүүлэх;

3.1.9.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шилжүүлсэн эрх, үүргийг хэрэгжүүлэх.

Дөрөвдүгээр зүйл.Жанжин штабын тамга, тэмдэг, бэлгэдэл, эд хөрөнгө

4.1.Жанжин штаб нь үйл ажиллагаандаа тогтоосон журмаар хийсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

4.2.Жанжин штаб нь эрхэлсэн ажлын онцлог, түүхэн уламжлалыг илэрхийлсэн бэлгэдэлтэй байна.

4.3.Дарга нь бэлгэдлийн загвар, тодорхойлолт, хэрэглэх журмыг тогтооно.

4.4.Жанжин штаб нь төрөөс өөрт олгосон эд хөрөнгөтэй байна.

4.5.Өөрт олгосон эд хөрөнгө болон хуульд заасны дагуу олсон орлогоороо бий болгосон эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна.

Тавдугаар зүйл.Жанжин штабын шагнал

5.1.Жанжин штаб нь дараах шагнал олгоно:

5.1.1.Жанжин штабын хүндэт тэмдэг;

5.1.2.Жанжин штабын хүндэт дэвтэрт бичих, дурсгалын гэрчилгээ;

5.1.3.Жанжин штабын хүндэт өргөмжлөл.

Зургаадугаар зүйл.Дүрэмд өөрчлөлт оруулах

6.1.Энэхүү дүрэмд Жанжин штаб, түүний бүтцийн нэгжийн дарга, төрлийн цэргийн командлагч нар өөрчлөлт оруулах санал гаргах эрхтэй бөгөөд уг саналыг Жанжин штабын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчид өргөн барина.